

“УЛСЫН НИСЭХИЙН БАГЦ ДҮРЭМ”-ИЙГ БАТЛАХ ТУХАЙ

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24.2 дахь хэсэг, “Зэвсэгт хүчний тухай хуулийн 7.1 дэх хэсэг, “Улсын нисэхийн тухай” хуулийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан “Улсын нисэхийн тухай” хуульд нийцүүлэн “Улсын агаарын хөлгийг бүртгэх, гэрчилгээ олгох дүрэм”-ийг нэгдүгээр, “Байлдааны агаарын хөлгөөс бусад улсын агаарын хөлгийн нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүнд мэргэжлийн үнэмлэх олгох дүрэм”-ийг хоёрдугаар, “Улсын нисэхийн аэродромын бүсэд нислэг үйлдэх болон аэродромыг ашиглах дүрэм”-ийг гуравдугаар, “Улсын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт тавих дүрэм”-ийг дөрөвдүгээр, “Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагааг зохицуулах дүрэм”-ийг тавдугаар, “Эрэн хайх, авран туслах ажиллагааг гүйцэтгэх дүрэм”-ийг зургаадугаар, “Улсын нисэхийн агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах дүрэм”-ийг долоодугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. “Улсын нисэхийн багц дүрэм”-ийг 2019 оны 05 дугаар сарын -ний өдрөөс эхлэн улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудад мөрдүүлэх, энэ талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штаб/ хошууч генерал А.Ганбат/-т үүрэг болгосугай.

3. Тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 330 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /хурандаа Д.Ганхуяг/-т даалгасугай.

САЙД

Н.ЭНХБОЛД

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
05 дүгээр сарын 28-ны өдрийн А/150 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

УЛСЫН АГААРЫН ХӨЛГИЙГ БҮРТГЭХ, ГЭРЧИЛГЭЭ
ОЛГОХ ДҮРЭМ
УНД-1

Нийтлэг үндэслэл

Энэ дүрмээр улсын агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх болон бүртгэлтэй агаарын хөлөгт бүртгэлийн гэрчилгээ, нислэгт тэнцэх чадвар (цаашид НТЧ гэх)-ын гэрчилгээ, таних тэмдэг олгох, түүнийг байрлуулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

Энэ дүрмийг улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагууд дагаж мөрдөнө.

Нэг. Улсын агаарын хөлгийн бүртгэл

1.1. Улсын агаарын хөлгийг бүртгэх

1.1.1. Улсын агаарын хөлөг нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас олгосон хүчин төгөлдөр бүртгэлийн гэрчилгээтэй байна.

1.1.2. Улсын агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах ажиллагааг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс гүйцэтгэнэ.

1.1.3. Өөр улсад болон иргэний нисэхэд бүртгэлтэй агаарын хөлгийг улсын нисэхэд түрээсээр ашиглах тохиолдолд түр хугацаагаар бүртгэлд авна.

1.1.4. Улсын агаарын хөлгийн бүртгэлд “Иргэний нисэхийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтад заагдсан агаарын хөлгүүд хамаарахгүй.

1.2. Улсын агаарын хөлгийг бүртгүүлэх өргөдөл

1.2.1. Агаарын хөлгийг бүртгүүлэхээр өргөдөл гаргагч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага/ нь тухайн агаарын хөлгийн хууль ёсны эзэмшигч байгууллагын дарга /захирагч/ байна.

1.2.2. Өргөдөл гаргагч нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс гаргасан бүртгэлийн маягт /хавсралт.№1/-ыг бөглөж ирүүлнэ.

1.2.3. Өргөдөлд дараах зүйлийг тусгана:

- агаарын хөлгийн маяг, үйлдвэрлэгчээс олгосон дугаар, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, код;

- эзэмшигч байгууллагын албан ёсны нэр, хаяг;

- агаарын хөлөг болон түүнийг эзэмшигч байгууллагатай холбоотой нэмэлт мэдээлэл.

1.2.4. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс нь шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчаас дор дурьдсан зүйлийг шаардаж болно. Үүнд:

- агаарын хөлгийн маяг, үйлдвэрлэгчээс олгосон дугаар, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, кодыг нотолсон баримт, материал;

- өргөдөл гаргагчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

1.3. Улсын агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ олгох

1.3.1 Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчийн агаарын хөлгийг Улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно. Үүнд:

- тухайн агаарын хөлөг нь өөр улсын бүртгэлээс хасагдсан байх;

- өргөдөл гаргагч нь өргөдөл гаргасан өдрөөс хойш бүртгэлийн гэрчилгээ олгох хүртэлх хугацаанд тухайн агаарын хөлгийн хууль ёсны эзэмшигч байх.

1.3.2. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс нь агаарын хөлгийн бүртгэлд дараах зүйлийг тусгана:

- бүртгэсэн он, сар, өдөр;

- өргөдөлд дурьдсан агаарын хөлөгт хамаарах мэдээлэл;

- агаарын хөлгийн хууль ёсны эзэмшигчийн нэр, хаяг;

- агаарын хөлөгт өгсөн бүртгэлийн дугаар, таних тэмдэг.

1.4. Бүртгэлийн гэрчилгээний эзэмшигчийг солих

1.4.1. Өмнөх бүртгэлийн гэрчилгээ нь түүнийг эзэмшигч агаарын хөлгийн эзэмшлийг солиулахаар өргөдөл гаргасан өдрөөс эхлэн хүчингүйд тооцогдоно.

1.4.2. Шинээр бүртгэлийн гэрчилгээ эзэмшихээр хүсэлт гаргагч нь өмнөх гэрчилгээг хүчингүй болгосноос хойш 14 хоногийн дотор Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс гаргасан бүртгэлийн маягыг бөглөж ирүүлнэ.

1.5. Бүртгэлийн гэрчилгээг солих, дахин олгох

1.5.1. Бүртгэлийн гэрчилгээг:

- алдаж үрэгдүүлсэн;
- гэрчилгээн дээрх бичилт гэмтсэн;
- гэрчилгээнд өөрчлөлт оруулах шаардлага гарсан зэрэг

шалтгаанаар солих буюу дахин олгоно.

Энэ тохиолдолд гэрчилгээг солиулах болон шинээр авах тухай хүсэлтээ Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст гаргана.

1.5.2. Гэрчилгээ солиулахаар хүсэлт гаргагч нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс гаргасан бүртгэлийн маягтыг бөглөж, солиулах болон шинээр авах болсон шалтгааныг нотолсон баримтын хамт ирүүлнэ.

1.6. Бүртгэлийн гэрчилгээний хугацаа

1.6.1. Бүртгэлийн гэрчилгээний хугацааг тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс олгосон ашиглалтын хугацаагаар тогтооно.

1.6.2. Бүртгэлийн гэрчилгээ нь гэрчилгээ эзэмшигч уг агаарын хөлгийг хууль ёсоор эзэмшихээ болих, эсхүл Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс гэрчилгээний хугацааг түр түдгэлзүүлэх буюу хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

1.6.3. Бүртгэлийн гэрчилгээний хугацааг түр түдгэлзүүлсэн тохиолдолд эзэмшигч нь гэрчилгээг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст ирүүлнэ.

1.6.4. Бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон, эсхүл гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийг хууль ёсоор эзэмшихээ больсон тохиолдолд гэрчилгээг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст нэн даруй хураалгана.

1.7. Агаарын хөлгийн тухай мэдүүлэг

1.7.1. Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст агаарын хөлгийн тухай мэдүүлгийг албан бичгээр ирүүлнэ:

- агаарын хөлгийг удаан хугацаагаар ашиглалтаас чөлөөлөх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх болон агаарын хөлөг сүйрсэн, алга болсон, хулгайлагдсан тухай мэдсэнээс хойш 14 хоногийн дотор;

- агаарын хөлгийг өөр улсад бүртгүүлэх, шилжүүлэх болсон.

1.7.2. Мэдүүлэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ашиглалтаас чөлөөлөх, шилжүүлэх нөхцөл байдлыг тодорхой заасан байх;

- бүртгэлийн гэрчилгээг хавсаргасан байх;

- агаарын хөлгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх болсон тухай харьяалах асуудал эрхэлсэн сайдын тушаал гарсан байх.

1.8. Бүртгэлээс хасах

1.8.1. Хэрэв агаарын хөлгийг тодорхой хугацаагаар бүртгэсэн бол хугацаанаас нь өмнө хүчингүй болгохоос бусад тохиолдолд тухайн хугацаа дууссанаар бүртгэлээс хасагдсанд тооцно.

1.8.2. Агаарын хөлгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна.

- бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн бүртгэлийг хүчингүй болгуулахаар Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст хүсэлт гаргасан.

- агаарын хөлөг нь ашиглалтаас хасагдсан;

- агаарын хөлгийг өөр улсад бүртгүүлэх, шилжүүлэх болсон;

- иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх болсон;

- бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон;

1.8.3. Агаарын хөлгийг бүртгэлд бүртгэх хугацааг түдгэлзүүлэх, хугацаанаас өмнө хүчингүй болгох, бүртгэлээс хасахтай холбогдсон асуудлыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс гаргасан дүгнэлтийг үндэслэн Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч шийдвэрлэнэ.

1.9. Агаарын хөлгийн харьяалал

1.9.1. Агаарын хөлгийг энэ дүрмийн дагуу бүртгүүлж, гэрчилгээ авсан өдрөөс эхлэн улсын нисэхийн агаарын хөлөгт тооцно.

Хоёр. Улсын агаарын хөлгийн таних тэмдэг, түүнийг батлах, тооллогын дугаар олгох, байрлуулах

2.1. Улсын болон бүртгэлийн таних тэмдэг

2.1.1. Улсын нисэхэд бүртгэлтэй зорчигч, ачаа тээврийн зориулалттай агаарын хөлгийн Улсын таних тэмдэг нь “МТ” /монгол тээвэр/ гэсэн кирилл том үсгээр бичигдэнэ.

2.1.2. Улсын нисэхэд бүртгэлтэй зорчигч, ачаа тээврийн зориулалттай агаарын хөлгийн бүртгэлийн таних тэмдэг нь 4 оронтой тооноос бүрдэх ба Улсын таних тэмдгээс холбоос зураасаар тусгаарлагдсан байна.

2.1.3. Улсын нисэхэд бүртгэлтэй байлдааны, сургууль-байлдааны, сургуулийн болон тусгай зориулалтын агаарын хөлөгт зөвхөн бүртгэлийн таних тэмдэг байрлуулах ба тэр нь 3 оронтой тооноос бүрдэнэ.

2.1.4. Улсын нисэхэд бүртгэлтэй агаарын хөлгийн улсын болон бүртгэлийн таних тэмдгийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас олгоно.

2.1.5. Бүртгэлийн таних тэмдгийг өөр агаарын хөлөгт давхардуулан олгохгүй.

2.1.6. Улсын агаарын хөлгийн улсын болон бүртгэлийн таних тэмдгийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн зөвшөөрөлгүйгээр байрлуулах, өөрчлөхийг хориглоно.

2.2. Бүртгэлийн таних тэмдгийг солих

2.2.1. Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч гэрчилгээнд заасан бүртгэлийн таних тэмдгээ солих тухай хүсэлтээ Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст гаргана.

2.2.2. Бүртгэлийн таних тэмдгээ солиулахаар хүсэлт гаргагч нь өргөдөл, бүртгэлийн гэрчилгээ, санал болгож байгаа бүртгэлийн таних тэмдгийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст ирүүлнэ.

2.2.3. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс нь өргөдлийг хүлээн аваад урьд олгосон бүртгэлийн таних тэмдгийг хүчингүйд тооцож, бүртгэлийн шинэ таних тэмдэг олгох асуудлыг шийдвэрлэнэ.

2.2.4. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс бүртгэлийн шинэ таних тэмдгийг олгосон тохиолдолд улсын агаарын хөлгийн бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулна.

2.3. Таних тэмдгийг агаарын хөлөгт байрлуулах

2.3.1. Улсын агаарын хөлгийн таних тэмдгийг:

- далавчинд;
- агаарын хөлгийн их бие, эсхүл сүүлний босоо хэсэг дээр тус тус байрлуулна.

2.3.2. Таних тэмдгийг далавчинд байрлуулах тохиолдолд агаарын хөлгийн далавчны доод талд байрлуулна.

2.3.3. Таних тэмдгийг их биений гадаргууд байрлуулах тохиолдолд агаарын хөлгийн далавч болон сүүлний хэсгийн хооронд, их биений хоёр талд байрлуулна.

2.3.4. Таних тэмдгийг сүүлний босоо хэсэгт дараах байдлаар байрлуулна:

- агаарын хөлөг нэг босоо сүүлтэй бол түүний хоёр талд;
- агаарын хөлөг хоёр босоо сүүлтэй бол сүүлний гадна талуудад байрлуулна.

2.3.5. Таних тэмдэг нь байрлуулах гадаргууны захаас 50 мм-ээс багагүй зайд байна.

2.3.6. Улсын нисэхэд бүртгэлтэй дараах агаарын хөлгүүдэд улсын болон бүртгэлийн таних тэмдгийг байрлуулахгүй байж болно:

- 5700 кг буюу түүнээс доош хөөрөлтийн жинтэй онгоц /нисдэг тэрэг/;
- мотортой болон моторгүй хэт хөнгөн онгоц /автожир/.

2.4. Таних тэмдэгт тавигдах шаардлага

2.4.1. Агаарын хөлгийн улсын болон бүртгэлийн таних тэмдгүүд нь элдэв маяггүй, кирилл том үсэг, араб тооноос тус тус бүрдэнэ.

2.4.2. Үсэг, тоо бүрийн өргөн болон холбоос зураасны урт нь үсэг буюу тооны өндрийн гуравны хоёроос багагүй байна.

2.4.3. Үсэг, тоо буюу холбоос зураас бүрийн хоорондын зай нь үсэг, тооны дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний зайгаар тусгаарлагдсан байна.

2.4.4. Үсэг, тоо болон холбоос зураас нь таних тэмдгийн өндрийн зургааны нэгтэй тэнцэх өргөн бүхий үргэлжилсэн шугамаар зурагдана.

2.4.5. Улсын болон бүртгэлийн таних тэмдгүүд нь ижил өндөртэй бичигдэнэ.

2.4.6. Таних тэмдгийн өндөр нь далавчинд 500 мм-ээс, их биед 150 мм-ээс багагүй байна.

2.4.7. Улсын болон бүртгэлийн таних тэмдгийг:

- гадны аливаа нөлөөнд хялбар гэмтэж арилахгүйгээр будаг болон бусад материалаар хийнэ;

- агаарын хөлгийн хийц, загварын онцлогоос хамааран хамгийн тохиромжтой хэсэгт, ил харагдахуйц газар байрлуулсан байна.

2.4.8. Үсэг, тоо болон холбоос зураас бүр нь ижил өнгөтэй байх бөгөөд суурь гадаргуугаас тод ялгаран харагдахаар байна.

2.5. Лого буюу ялгах тэмдэг

2.5.1. Улсын агаарын хөлгийн эзэмшигч нь хуулиар зөвшөөрөгдсөн өөрийн лого буюу ялгах тэмдгийг агаарын хөлөгтөө байрлуулж болно.

2.5.2. Лого буюу ялгах тэмдгийн хэмжээ, байрлалыг агаарын хөлгийн эзэмшигч өөрөө сонгоно.

Гурав. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ

3.1. Гэрчилгээний ангилал

3.1.1. Нислэгт тэнцэх чадвар /НТЧ/-ын гэрчилгээ нь тухайн агаарын хөлгийг нислэгт ашиглах зориулалт, хугацаа, хязгаарлалт, техникийн чадавхийг илэрхийлж баталгаажуулсан хууль ёсны баримт бичиг болно.

3.1.2. НТЧ-ын гэрчилгээний ангилал нь тухайн агаарын хөлгөөр нислэгийн үүрэг гүйцэтгэх зориулалтыг тодорхойлно.

3.1.3. Улсын агаарын хөлөгт дараах ангиллын НТЧ-ын гэрчилгээ олгоно:

- стандарт /суудлын болон ачааны зориулалтын/;
- хязгаарлагдмал /тусгай тоноглолтой/.

3.1.4. НТЧ-ын стандарт ангиллын гэрчилгээг үйлдвэрлэгчээс тогтоосон зориулалтаар нь ашиглагдаж буй агаарын хөлөгт олгоно.

3.1.5. НТЧ-ын хязгаарлагдмал ангиллын гэрчилгээг тусгай зориулалтын тоноглолоор өөрчлөн тоноглогдсон агаарын хөлөгт олгоно.

3.1.6. Дараах тохиолдолд НТЧ-ын стандарт болон хязгаарлагдмал ангиллын гэрчилгээг хамт олгож болно. Үүнд:

- улсын агаарын хөлөг нь ангилал тус бүрийн шаардлагыг хангаж байгаа бол,
- агаарын хөлөгт энгийн механик аргаар тоног төхөөрөмж суурилуулах, авахад агаарын хөлөг нь нэг бүтцээс нөгөө бүтцэд шилжиж чаддаг бол.

3.1.7. Сургуулийн, тусгай тоноглолтой, хөдөө аж ахуйд ашиглахаар тоноглогдсон улсын агаарын хөлөгт хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ олгох ба тээврийн зориулалтаар ашиглахыг хориглоно.

3.1.8. Байлдааны, сургууль-байлдааны зориулалттай агаарын хөлөгт НТЧ-ын гэрчилгээг олгохгүй.

3.2. Гэрчилгээ олгох

3.2.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн дүгнэлтийг үндэслэн Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын агаарын хөлгийн НТЧ-ын гэрчилгээг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч олгоно.

3.3. Стандарт болон хязгаарлагдмал ангиллын гэрчилгээ олгоход тавигдах шаардлага

3.3.1. Улсын агаарын хөлөгт стандарт болон хязгаарлагдмал ангиллын НТЧ-ын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь:

- үйлдвэрээс олгогдсон гэрчилгээ нь тухайн агаарын хөлгийн ашиглалтын зориулалттай нийцсэн байх;
- томоохон өөрчлөлт, засвар нь тухайн агаарын хөлгийн загварын өөрчлөлтөөр баталгаажсан байх;
- агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын заавар, бүхээгийн бүртгэлийн дэвтэр, техникийн баримт бичигт засвар, өөрчлөлт хийгдсэн тухай бичигдсэн байх;
- агаарын хөлөг нь улсын болон бүртгэлийн таних тэмдэгтэй байх;
- агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс, сэнсний гол болон алганы тодорхойлолтыг гаргасан байх;
- агаарын хөлөг нь ашиглалтын аюулгүй байдлыг хангасан нөхцөлд байх зэрэг шаардлагыг хангасан байна.

3.4. Гэрчилгээний хугацаа

3.4.1. НТЧ-ын гэрчилгээ нь нэг жил хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

3.4.2. НТЧ-ын гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд агаарын хөлгийн техник үйлчилгээ нь тухайн төрлийн техникийн ашиглалтын заавар болон бусад холбогдох журам, зааврын дагуу хийгдсэн байна.

3.4.3. НТЧ-ын гэрчилгээний хугацаа дуусахаас 14-өөс багагүй хоногийн өмнө Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ.

3.4.4. Агаарын хөлгийг нислэгт ашиглах зориулалт, хугацаа, хязгаарлалт, техникийн үзүүлэлтүүд нь шаардлага хангахгүй, баримт бичиг нь зөрчилтэй бол НТЧ-ын гэрчилгээний хүчинтэй байх хугацааг түдгэлзүүлэх тухай Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс гаргасан дүгнэлтийг үндэслэн Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч шийдвэрлэнэ.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
.... дүгээр сарын-ны өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

БАЙЛДААНЫ АГААРЫН ХӨЛГӨӨС БУСАД УЛСЫН АГААРЫН ХӨЛГИЙН
НИСЭХ БАГ, ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН БҮРЭЛДЭХҮҮНД
МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ДҮРЭМ
УНД-2

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нисэх баг, инженер техникийн мэргэжилтнүүдэд мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл олгоход тавигдах шаардлага, тэдний эрх, үүргийг тогтооход энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Энэ дүрмийг улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагууд дагаж мөрдөнө.

“Мэргэжлийн үнэмлэх” гэж нисэхийн мэргэжилтнүүдэд тухайн төрөл мэргэжлээр нь ажиллуулахаар эрх олгосныг гэрчлэх баримт бичгийг;

“Мэргэжлийн зэрэг” гэж нисэхийн мэргэжилтнүүдийн онолын мэдлэг, мэргэжлийн дадлага, ур чадварын үнэлэмж /илэрхийлэл/-ийг;

“Зэрэглэл” гэдэг нь нисэхийн мэргэжилтнүүдийг мэргэжил, гүйцэтгэх үүргээр нь ангилсан ангилал ба шатлалыг;

“Шалгагч нисгэгч” гэж нисэх багт оролцон нислэгийг шалгах буюу дадлагажуулах зорилгоор тухайн агаарын хөлөг дээр шалган зааварлах эрх бүхий албан тушаалтныг;

“Багш нисгэгч” гэж нисгэгчийн нислэг үйлдэх үйл ажиллагааг шалгах буюу сурган дадлагажуулах, зааварлах эрх бүхий албан тушаалтныг;

“Байцаагч нисгэгч” гэж улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага, нисэх баг, агаарын хөлгийн нислэгийн ашиглалттай холбогдсон эрхийн хязгаарлалтыг тогтоох эрх бүхий албан тушаалтныг;

“Байцаагч инженер” /ерөнхий инженер/ гэж улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага, инженер техникийн бүрэлдэхүүн, нисэхийн техникийн ашиглалт, хадгалалттай холбоотой эрхийн хязгаарлалтыг тогтоох эрх бүхий албан тушаалтныг,

“Шалгагч инженер” гэж агаарын хөлөг дээр ажиллах бүрэлдэхүүнийг шалгах, дадлагажуулах, агаарын хөлөг болон үйлчилгээний техник хэрэгслийг шалгах, зааварлах эрх бүхий албан тушаалтныг;

“Агаарын хөлгийн төрөл” гэж онгоц, нисдэг тэрэг, агаарын бөмбөлөг, планер гэх зэргээр ангилсныг;

“Нэг нисгэгчтэй агаарын хөлөг” гэж тухайн агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааврын дагуу нэг нисгэгчтэйгээр /нисэх баг нэг хүн/ нислэг үйлдэхээр зөвшөөрөгдсөн агаарын хөлгийг;

“Зөөлтийн нислэг” гэж багш нисгэгчийн шууд удирдлага, хяналт, зааварчилгаагаар үйлдэх нислэгийг хэлнэ.

Хоёр. Мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэлд тавигдах ерөнхий шаардлага

2.1. Улсын агаарын хөлгийн нисгэгч, нисэх багийн гишүүд, инженер, техникийн бүрэлдэхүүн нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас олгосон хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэлтэй байна.

2.2 Мэргэжлийн үнэмлэх эзэмшигч нь:

- нисэхийн тухайн мэргэжлээр сургууль, дамжаа төгссөн диплом, гэрчилгээтэй байх;
- тухайн агаарын хөлгийн нислэг, техникийн сургалтын хөтөлбөрийг хангасан, нислэг үйлдэх болон ажиллах эрх олгогдсон байх;
- эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн байх зэрэг шаардлагуудыг хангасан байна.

2.3. Улсын агаарын хөлгийн нисгэгч, нисэх багийн гишүүд, инженер, техникийн бүрэлдэхүүн нь нисэхийн мэргэжлийн зэргийн тэмдэгтэй байна.

Гурав. Нисэх баг, инженер, техникийн бүрэлдэхүүний мэргэжлийн зэрэг, зэрэглэл

3.1. Нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүний мэргэжлийн зэрэг, зэрэглэлийг дараах байдлаар тогтооно:

3.1.1. Мэргэжлийн зэргийг:

- байлдааны нисгэгчийн III, II, I;
- тээврийн нисгэгчийн III, II, I;
- нисэх-инженер /бортмеханикч/-ийн III, II, I;
- нисэн-хянагч /штурман/-ийн III, II, I;
- нислэгийн удирдагчийн III, II, I;
- техникчийн III, II, I гэж ангилна.

3.1.2. Мэргэжлийн зэрэглэлийг:

- хэрэглэлийн нислэгийн;
- багш-нисгэгчийн;
- шалгагч-нисгэгчийн;

- нисэх-инженер /бортмеханикч/ багшийн;
- нисэх-инженер /бортмеханикч/ шалгагчийн;
- нисэн-хянагч /штурман/ багшийн;
- нисэн-хянагч /штурман/ шалгагчийн гэж ангилна.

Дөрөв. Үнэмлэх олгох

4.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс нь мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэлийг олгохдоо Агаарын цэргийн командлагчийн баталсан “Нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, зэрэг олгох заавар”-ыг баримтална.

4.2. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн санал, дүгнэлтийг үндэслэн мэргэжлийн үнэмлэхийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч олгож, жил бүр баталгаажуулна.

Тав. Бусад зүйл

5.1 Улсын нисэхийн мэргэжлийн бүрэлдэхүүн ажил, үүрэг гүйцэтгэх хугацаандаа мэргэжлийн үнэмлэхээ биедээ авч явна.

5.2. Мэргэжлийн үнэмлэхээ алдаж, үрэгдүүлсэн тохиолдолд 7 хоногийн дотор Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэст хүсэлт гарган зохих төлбөр төлж, дахин авна.

5.3. Мэргэжлийн үнэмлэхгүй нисэх багийн гишүүд болон инженер, техникийн бүрэлдэхүүнийг нислэг, техникийн үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.

5.4. Энэхүү дүрмийн 5.3 дахь хэсэгт байлдааны онгоц, нисдэг тэрэгний нисгэгч, нисэх багийн гишүүд болон инженер, техникийн бүрэлдэхүүнд хамаарахгүй.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
.... дүгээр сарын-ны өдрийн дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

УЛСЫН НИСЭХИЙН АЭРОДРОМЫН БҮСЭД НИСЛЭГ ҮЙЛДЭХ БОЛОН
АЭРОДРОМЫГ АШИГЛАХ ДҮРЭМ
УНД-3

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмээр улсын нисэхийн аэродром байгуулах, бүртгэх, түүнд тавигдах шаардлага, бэлэн байдал, аэродромын бүсэд нислэг үйлдэх болон тэдгээрийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

Энэ дүрмийг улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагууд дагаж мөрдөнө.

1.2. Улсын нисэхийн аэродромын бүртгэл, гэрчилгээжүүлэлт, бэлэн байдал, ашиглалтад тавигдах шаардлагуудын биелэлтэд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал хяналт тавина.

1.3. Улсын нисэхийн аэродром нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн баталсан “Аэродромын бүсэд нислэг үйлдэх заавар”-тай байна.

1.4. Улсын нисэхийн аэродромын бэлэн байдлыг тухайн аэродромыг эзэмшигч байгууллагын дарга /захирагч/ хариуцна.

1.5. Улсын нисэхийн аэродромыг иргэний нисэхийн байгууллагуудтай хамтран ашиглахаар бол Батлан хамгаалах болон Зам, тээвэр хариуцсан яамдын сайд нарын хамтран баталсан “Улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах журам”-ыг баримтална.

1.6. Улсын нисэхийн аэродромуудыг зориулалтаар нь байнгын, үндсэн, бэлтгэл болон түр, үзүүлэлтүүдээр нь 1, 2, 3 дугаар зэрэглэлийн гэж ангилна. Үүнд:

- нэгдүгээр зэрэглэлийн аэродромын хөөргөх, буулгах зурвас нь 2500-3000 м-ийн урттай, хатуу хучилттай, аэродромын гэрэлтүүлэг, техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон болон хөөргөх, буулгах нөөц зурвастай байна.

- хоёрдугаар зэрэглэлийн аэродромын хөөргөх, буулгах зурвас нь 1800-2400 м-ийн урттай, хатуу болон шороон хучилттай, аэродромын гэрэлтүүлэг, техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон байна.

- гуравдугаар зэрэглэлийн аэродромын хөөргөх, буулгах зурвас нь 1200-1700 м-ийн урттай, хөдөлгөөнт гэрэлтүүлэг, техник хэрэгслээр тоноглогдсон байна.

Хоёр. Аэродром байгуулах

2.1. Улсын нисэхийн аэродромыг шинээр байгуулах, ашиглах, ашиглалтаас хасах асуудлыг “Улсын нисэхийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн дагуу шийдвэрлэнэ.

2.2. Улсын нисэхийн аэродром орчмын нутаг дэвсгэрийн ойролцоо барилга, байгууламж, холбооны болон өндөр хүчдэлийн шугам барьж байгуулах санал тавьж буй байгууллага нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабаас зөвшөөрөл авна.

Гурав.Бүртгэх

3.1. Улсын нисэхийн аэродром нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас олгосон бүртгэлийн гэрчилгээтэй байна.

3.2. Улсын нисэхийн аэродромыг бүртгэж, гэрчилгээ олгох асуудлыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс хариуцна.

3.3. Улсын агаарын хөлгийн эзэмшигч байгууллага нь түр аэродромыг байгуулах, ашиглахдаа Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн зөвшөөрлөөр түр гэрчилгээ авна.

3.4. Бүртгэл, гэрчилгээгүй аэродромыг улсын нисэхэд ашиглахыг хориглоно.

Дөрөв. Аэродромын бэлэн байдал

4.1. Улсын нисэхийн аэродромын бэлэн байдлыг хангах асуудлыг тухайн аэродромыг эзэмшигч байгууллагын дарга /захирагч/ хариуцна.

4.2. “Аэродромын бэлэн байдал” гэдэгт тухайн аэродромын зэрэглэлээс шалтгаалан агаарын хөлгийг буулгах, хөөргөх, байрлуулах үеийн нислэг, хөдөлгөөний удирдлага, нисэхийн аюулгүй байдлыг хангах, аэродромын бүх төрлийн хангалт, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой цогц үйл ажиллагааг ойлгоно.

4.3. Аэродромын бэлэн байдал нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- мэргэжлийн боловсон хүчний хангалт, тэдгээрийн бэлтгэл;
- аэродром, техникийн хангалт;
- нисэхийн холбоо-радиотехникийн хангалт;
- аэродромын гэрэлтүүлгийн техник хэрэгслийн хангалт;
- нислэгийн цаг уурын хангалт;
- ар талын хангалтууд;

- аюулгүй байдал, хамгаалалт багтана.

4.4. Тухайн аэродромын зориулалт, зэрэглэлээс хамаарч, түүний хангалтын төрөл өөр байж болно.

Тав. Аэродромд тавигдах шаардлага

5.1. Улсын нисэхийн аэродром нь “Улсын нисэхийн аэродромыг хамтран ашиглах журам”-д заагдсанаас гадна дараах нөхцлийг хангасан байна. Үүнд:

- өнгөлөн далдлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой байх;
- байгаль, цаг уур, газар орны нөхцлийг харгалзсан байх.

Зургаа. Аэродромын бүсэд нислэг үйлдэх

6.1. Аэродромын бүсэд болон зангилгаанд нислэг үйлдэхдээ “Аэродромын бүсэд нислэг үйлдэх заавар”-ыг баримтална.

6.2. Тухайн аэродромыг эзэмшигч байгууллага нь “Аэродромын бүсэд нислэг үйлдэх заавар”-ыг боловсруулан Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчаар батлуулж мөрдөнө.

Долоо. Аэродромын ашиглалт

7.1. Улсын нисэхийн аэродромуудыг ашиглахдаа “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай” хууль, “Улсын нисэхийн багц дүрэм” болон “Улсын нисэхийн аэродромуудыг хамтран ашиглах журам”, бусад холбогдох заавруудыг мөрдлөг болгоно.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
.... дүгээр сарын-ны өдрийн дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

УЛСЫН АГААРЫН ХӨЛГИЙН НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ
БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ ДҮРЭМ
УНД-4

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмээр нисэхийн техникийн бэлэн байдлыг хангах, нислэгт тэнцэх чадварыг хадгалах, нислэг-техникийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд явуулж буй техникийн болон эрх зүйн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Энэ дүрмийг улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагууд дагаж мөрдөнө.

“Нисэхийн техник” гэж нисгэгчтэй /нисгэгчгүй/ нисэх хэрэгсэл, тэдгээрийн хүчний төхөөрөмж, тоноглол, зэвсэглэл, нисэхийн хөнөөх хэрэгсэл, дадлага сургалтын суурин төхөөрөмж, ашиглалтын болон засвар, удирдлагыг хангах хэрэгслийг;

“Зорилтот үзлэг” гэж нисэхийн техникийн байдал, ашиглалтын нөхцөл, хугацаа зэргээс хамаарч тэдгээрийн зарим нэг эд анги, агрегат, систем, механизм ба бүтцийн элементүүдийг нарийвчлан шалгах зорилгоор хийж буй үзлэгийг;

“Зорилтот шалгалт” гэж нисэхийн техникийн ажиллагаа нь зохих журам, стандарт, шаардлагуудад нийцэж байгаа эсэхийг хэмжилтийн нарийн үйлдэл бүхий багаж тоноглол ашиглан бүх өгөгдөхүүнийг шалгаж бататгах, баримтжуулах үйлдлийг;

“Үйл ажиллагааны заавар” гэж улсын агаарын хөлгийн ашиглалттай холбоотой үйл ажиллагаанд мөрдлөг болгох баримт бичгийг;

“Агаарын хөлгийн ашиглалтын үйл ажиллагаа” гэж нисэх баг, нисэхийн инженер, техникийн ажилтнуудын хийх нислэг-техникийн төрөл бүрийн бэлтгэл, ажил үйлчилгээ, засвар, техникийн хяналтуудыг;

“Тусгай эрх” гэж үйлдвэрлэгч /зохион бүтээх товчоо/-ээс нисэхийн инженерүүдэд агаарын хөлөг, түүний эд ангид тусгай зориулалтын багаж хэрэгсэл, тоноглол ашиглан техникийн үйлчилгээ, үзлэгийг гүйцэтгүүлэхээр олгосон эрхийг;

“Техникийн үйлчилгээ” гэж агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварыг хадгалах үүднээс хийгдэх бүх төрлийн үзлэг, хугацаат болон хугацаат бус үйлчилгээг;

“Техникийн үйлчилгээнээс гаргах” гэж агаарын хөлөгт техникийн засвар, үйлчилгээ, үзлэг хийгдсэний дараа уг агаарын хөлөг нислэгт тэнцэх чадварын стандартад нийцэж буйг гэрчлэх эрх бүхий ажилтнаас баталгаажуулсныг;

“Нисэхийн техникийн ашиглалт” гэж нисэхийн техник хэрэгслүүдийг ашиглахтай холбогдсон бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэл, техникийн бэлэн байдал, засвар үйлчилгээ, хадгалалт хамгаалалтыг багтаасан цогц ойлголтыг хэлнэ.

Хоёр. Нисэхийн техникийн ашиглалт, үйл ажиллагаанд тавих хяналт

2.1. Нисэхийн техникийн талаар онолын зохих мэдлэг эзэмшиж, дадлага хийсэн, нисэхийн техникийн бүтэц, зохион байгуулалт, түүнийг ашиглах заавар, аюулгүйн арга хэмжээг өөрсдийн гүйцэтгэх албан үүргийн хэмжээнд судалж, зохих шалгалт, шүүлэг өгсөн нисэх болон инженер, техникийн бүрэлдэхүүнд нисэхийн техник дээр ажиллах эрхийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс олгоно.

2.2. Нисэхийн техник, хэрэгслүүдийн ашиглалттай холбоотой техникийн үзлэг, үйлчилгээг “Нисэхийн инженерийн албаны дүрэм”, тухайн техник, хэрэгслийн ашиглалтын зааврын дагуу явуулж буй эсэх, нисэхийн техникийн байдалд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс үнэлгээ өгч, баталгаажуулна.

2.3. Нисэхийн техник, хэрэгслүүдийн бэлэн байдал, ашиглалт, хадгалалтын байдалд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс хяналт тавина.

2.4. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс нь улсын нисэхийн техник, хэрэгслүүдийн ашиглалтад дараах хяналтуудыг тавина. Үүнд:

- удирдлагын баримт бичгийн хэрэгжилтэд;
- нисэх баг, инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн бэлтгэл, баримт бичгийн бүрдэлд;
- техник, хэрэгслүүдийн үйлдвэрлэгч /нийлүүлэгч/-ээс олгосон ашиглалтын хугацаанд;
- агаарын хөлгийн бүртгэл, гэрчилгээжилтийн байдалд;

- нисэхийн техник, хэрэгслүүдийн сэлбэг материалын хангалт, зарцуулалт, хадгалалтад;
- агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, редуктор, бусад тоног төхөөрөмжүүдийг солих, шилжүүлэн тавихад болон түүний дараах шалгалтын нислэг үйлдэхэд;
- онцгой үүргийн нислэгийн өмнөх бэлтгэлд;
- агаарын хөлгийг түр буюу удаан хугацааны хадгалалтад тавих, хадгалах, хадгалалтаас гаргах явцад;
- аэродром, нисэхийн холбоо, радиотехникийн хангалтын техник, хэрэгслүүдийн ашиглалтад;
- нислэг, техникийн ашиглалтын явцад гарсан зөрчил, дутагдлыг арилгасан байдалд.

Гурав. Үзлэг шалгалт хийх

3.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн зорилгот үзлэг, шалгалт хийх төлөвлөгөөг командлалын жилийн ажлын хөтөлбөрт тусгасан байна.

3.2. Зорилтот үзлэг, шалгалтыг улирал тутамд төлөвлөгөөний дагуу явуулж, дүнг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчид илтгэнэ.

3.3. Зорилтот үзлэг, шалгалтыг явуулахдаа дараах баримт бичгүүдийг үндэслэнэ. Үүнд:

- Нисэхийн инженерийн албаны дүрэм;
- тухайн техник, хэрэгслийн техникийн ашиглалтын заавар;
- дээд байгууллагаас баталсан удирдлагын бусад баримт, бичгүүд.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
.... дүгээр сарын-ны өдрийн дугаар
тушаалын тавдугаар хавсралт

УЛСЫН АГААРЫН ХӨЛГИЙН НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ДҮРЭМ
УНД-5

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрэм нь улсын агаарын хөлгийн байлдааны болон бусад үүргийн нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, удирдах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихад чиглэгдэнэ.

Энэ дүрмийг улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагууд дагаж мөрдөнө.

1.2. Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний хяналт нь байлдааны болон бусад үүргийн нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, агаарын зайн зөрчлийг илрүүлэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, дахин гаргуулахгүй байх үйл ажиллагаанд чиглэгдэнэ.

1.3. Шаардлагатай тохиолдолд нислэгийн хөдөлгөөнд тавих хяналтыг байлдааны онгоц, нисдэг тэрэг ашиглан гүйцэтгэж болно.

1.4. Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнд тавих хяналтын үндэс нь радиолокац /бодит хяналт/-ийн болон диспетчер /мэдээлэлд тулгуурласан/-ийн арга байна.

1.5. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь “Улсын нисэхийн тухай”, “Иргэний нисэхийн тухай”, “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай” хуулиуд, “Агаарын зайг нисэхэд ашиглах ерөнхий журам”, “Улсын нисэхийн багц дүрэм”-ийг үндэслэн Агаарын цэргийн нислэгийн хөдөлгөөний албаны нислэгийн удирдагч /нислэгийн хөдөлгөөний зохицуулагч/-аар дамжуулан улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагаанд хяналт тавина.

1.6. Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагааны хяналтыг ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба болон тухайн агаарын хөлгийг эзэмшигч байгууллага өөрийн штаб, удирдлагын байрууд, албадаар дамжуулан радиолокац /бодит хяналт/-ийн болон диспетчер /мэдээлэлд тулгуурласан/-ийн аргаар зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Хоёр. Нислэгийн хөдөлгөөний хяналт

2.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн төв командын байр нь байлдааны жижүүрлэлтийн анги, салбаруудыг нэгтгэн удирдах, агаарын зай, нислэгийн хөдөлгөөнд радиолокац /бодит хяналт/-ийн болон диспетчер /мэдээлэлд тулгуурласан/-ийн хяналт тавих, ЗХЖШ, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, холбогдох бусад байгууллагуудыг агаарын цагийн байдлын тухай бодит мэдээллээр хангах үүргийг хүлээнэ.

2.2. “Агаарын цэргийн нислэгийн хөдөлгөөний алба” нь дараах үндсэн үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- улсын болон иргэний нисэхийн агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын нислэгийн хоногийн нэгдсэн төлөвлөлтийг ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албатай хамтран боловсруулах;

- төлөвлөгдсөн нислэгийн нөхцөл, захиалгыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн төв командын байр болон агаарын хөлгийг эзэмшигч байгууллагуудын штаб, удирдлагын байранд мэдээлэх;

- ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албатай хамтран аюул тулгарсан буюу аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах зорилгоор үйлдэж буй агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнд хяналт тавих;

- улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөнд хяналт тавих;

- улсын агаарын хөлгийн нислэгийн горимд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

- улс орныг батлан хамгаалах, цэргийн сургалт явуулах зорилгоор пуужингийн харвалт, зенитийн буудлага, хээрийн болон нислэг-тактикийн байлдааны буудлагатай сургуулийг зохион байгуулах үед орон нутгийн хязгаарлалттай буюу хориотой бүсүүдийг тогтооход оролцох, уг арга хэмжээг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад урьдчилан мэдээлж, зохицуулалт хийх, биелэлтэд нь хяналт тавих;

- улсын болон иргэний нисэхийн агаарын хөлгийн нислэгийн онцгой тохиолдол, цаг агаарын аюултай үзэгдлийн үед аэродром, холбоо аэронавигаци, цаг уурын хангалт, нислэгийн хөдөлгөөний зохицуулалт хийх.

2.3. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг удирдах, хяналт тавих, нисэхийн аюулгүй байдлыг хангах

зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэр дээр дараах “аэродромуудын зангилаа”-г зохион байгуулна. Үүнд:

- Улаанбаатарын зангилаа: “Чингисхаан” ОУНБ, Мандалговь, Даланзадгад, Арвайхээр, Мөрөн, Хатгал, Булган, Эрдэнэт;
- Налайхын зангилаа: Налайх, Мааньт, Чойр, Даланжаргалан, Сайншанд;
- Чойбалсангийн зангилаа: Чойбалсан, Баруун-Урт, Өндөрхаан;
- Ховдын зангилаа: Ховд, Алтай, Өлгий, Улаангом, Улиастай, Тосонцэнгэл, Баянхонгор, Ховдын Булган.

2.4. Аэродромын зангилааны бүтэц, түүнийг зохион байгуулах, ашиглах тусгай зааврыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал боловсруулж, ЗХЖШ-ын даргаар батлуулан мөрдөнө.

2.5. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь Улсын хилийн агаарын бүсэд тавих хяналтыг ИНЕГ болон ХХЕГ-тай хамтран зохион байгуулна.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
.... дүгээр сарын-ны өдрийн дугаар
тушаалын зургаадугаар хавсралт

ЭРЭН ХАЙХ, АВРАН ТУСЛАХ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ДҮРЭМ УНД-6

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмээр улсын нисэхийн эрэн хайх, авран туслах ажлыг зохион байгуулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, түүний нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, авран туслах тэдгээрийг ослын газраас шилжүүлэн зөөвөрлөх үйл ажиллагааг ЗХЖШ тухайн агаарын хөлөг эзэмшигчтэй хамтран тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.

1.3. Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын болон иргэний нисэхийн байгууллагууд хамтран гүйцэтгэж болно.

1.4. Энэ дүрмийг улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагууд дагаж мөрдөнө.

“Авран туслах” гэж аюул тулгарсан, аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн нисэх баг, зорчигчдыг аврах, тэдэнд эмнэлгийн анхны болон бусад шаардлагатай тусламж үзүүлэх, аюулгүй газарт шилжүүлэн зөөвөрлөх үйл ажиллагааг;

“Эрэн хайх” гэж аюул тулгарсан, аюулд өртсөн агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох зорилгоор хүн хүч, төрөл бүрийн тээврийн хэрэгсэл оролцсон үйл ажиллагааг;

“Ослын мэдээлэл” гэж аюул тулгарсан, аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийн талаар эрэн хайх, авран туслах үйл ажиллагаанд оролцох байгууллага, албадад мэдээлдэг аэронавигацийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг;

“Тодорхой бус үе” /INCERFA/ гэж агаарын хөлөг болон түүнд яваа хүмүүсийн аюулгүй байдлын талаар эргэлзээ төрүүлсэн нөхцөл байдал бий болсон үеийг;

“Түгшүүрийн үе” /ALERFA/ гэж агаарын хөлөг болон түүнд яваа хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулж болохуйц хүчин зүйлүүд бий болсон үеийг;

“Аюулын үе” /DETRESFA/ гэж агаарын хөлөг болон түүнд яваа хүмүүст ноцтой аюул тулгарсан ба яаралтай тусламж шаардагдаж байгаа нь тодорхой болсон үеийг;

“Агаарын эрэн хайх, авран туслах бүлэг” гэж эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг зохих түвшинд гүйцэтгэх бололцоотой буюу энэ чиглэлээр бэлтгэгдсэн, ЭХАТ зориулалт бүхий хэрэгсэл бүхий агаарын хөлгийн нисэх баг болон аврагчид /шүхэрчид/-ын хэсгийг;

“Газрын эрэн хайх, авран туслах бүлэг” гэж тээврийн хэрэгсэл ашиглан аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийг газраар эрж хайх, зорчигчид болон нисэх багийн гишүүдэд тусламж үзүүлэх хэсгийг;

“Аврах хэрэгсэл, амьдрал тэтгэх эд зүйлс” гэж ослын нөхцөлд зорчигчид болон нисэх багийнхныг агаарын хөлгөөс гаргахад зориулагдсан хэрэгслүүд, хоол хүнс, цэвэр ус /эсхүл ус цэвэршүүлэгч/ эмнэлгийн анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа, гал болон гэрэл гаргах хэрэгсэл, холбоо дохиоллын хэрэгслийн тодорхой нөөцийг хэлнэ.

Хоёр. Эрэн хайх авран туслах бүлгийн бэлэн байдал

2.1. Эрэн хайх, авран туслах хүч хэрэгслийн бэлэн байдлын зэргийг ЗХЖШ-ын дарга тогтооно.

2.2. Нисэхийн ангиудын эрэн хайх, авран туслах хүч хэрэгсэл нь бэлэн байдлын дараах зэргүүдэд байна:

2.2.1. Бэлэн байдлын зэрэг №1

Онгоц /нисдэг тэрэг/ нэн даруй нисэхэд бэлэн, хөдөлгүүр асааж шалгагдсан, газрын цахилгаан үүсгүүрүүд залгагдсан, онгоц /нисдэг тэрэг/-ны бүхээгт аваарын болон аврах хэрэгслүүдийг байрлуулсан, ашиглахад бэлэн болсон байна. Нисэх бүрэлдэхүүн, шүхэр десантын бүлэг онгоц /нисдэг тэрэг/-н дотор ажлын байранд, харин техникийн бүрэлдэхүүн онгоц /нисдэг тэрэг/-ны дэргэд байрлана. Нислэгийг зохион байгуулах, эрлийн арга хэлбэр, аврах, тусламж үзүүлэх хэрэгслүүдийг ашиглах бүх заавар өгөгдсөн, нисэх багт үүрэг /даалгавар/ тавигдсан байна. Эрэн хайх, авран туслах бүлэг нэн даруй үүрэг гүйцэтгэхээр явахад бэлэн байна. Команд өгөгдсөнөөс хойш эрэн хайх, авран туслах бүлэг болон нисдэг тэрэгнүүд 10 минут, харин онгоцнууд 15 минутаас ихгүй хугацаанд гарсан байна.

2.2.2. Бэлэн байдлын зэрэг № 2

Онгоц /нисдэг тэрэгнүүд/-ууд нислэгт бэлэн, хөдөлгүүрийн ажиллагаа шалгагдсан, аваарын болон аврах хэрэгсэлүүдийг бүхээгт байрлуулсан, ашиглахад бэлтгэгдсэн байна. Нисэх болон техникийн бүрэлдэхүүн, шүхэр десантын бүлэг /аврагчдын бүлэг/ онгоцнууд /нисдэг тэрэгнүүд/-ын ойролцоо байна. Нислэгийг зохион байгуулах, эрлийн арга хэлбэр, аврах, тусламж үзүүлэх хэрэгслүүдийг ашиглах бүх заавар өгөгдсөн, нисэх багт үүрэг /даалгавар/

тавигдсан байна. Команд өгөгдсөнөөс хойш эрэн хайх, авран туслах бүлэг болон нисдэг тэрэгнүүд 20 минут, харин онгоцнууд 30 минутаас ихгүй хугацаанд гарсан байна.

2.2.3. Бэлэн байдлын зэрэг № 3

Онгоц /нисдэг тэрэгнүүд/-ууд, автомашинууд болон бусад ЭХАТ хэрэгслүүд ашиглахад бэлэн, тогтоогдсон байрлалд тавигдсан байна. Нисэх болон техникийн бүрэлдэхүүн, шүхэр десантын бүлэг /аврагчдын бүлэг/, эрэн хайх, авран туслах бүлэг хичээлийн, ажлын, эсхүл амралтын өрөөнд байна. Команд өгөгдсөнөөс хойш эрэн хайх, авран туслах бүлэг, онгоц болон нисдэг тэрэгнүүд зуны улиралд 90 минут, харин өвлийн улиралд 150 минутаас ихгүй хугацаанд гарсан байна.

Гурав. Эрэн хайх, авран туслах бүлгийн сургалт

3.1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрэн хайх, авран туслах бүлгийн сургалт, дадлагыг гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай хамтран жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

3.2. Улсын нисэхийн эрэн хайх, авран туслах бүлгийн сургалт, дадлагын төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгасан байна. Үүнд:

- эрэн хайх, авран туслах бүлгийн удирдах албан тушаалтнууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодотгох;
- байгууллагуудаас гаргах хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн ажиллах хуваарь;
- сургалт, дадлага явуулах район;
- сургалт, дадлага явуулах цаг хугацаа, хязгаарлалтууд;
- холбоо барих журам.

Дөрөв. Эрэн хайх авран туслах үйл ажиллагаа

4.1. Эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны өмнө болон үйл ажиллагаа явагдаж байх үед авсан бүх мэдээллийн үнэн зөв, бодитой эсэхийг сайтар магадлан шалгаж, авах арга хэмжээний цар хүрээг тодорхойлох зорилгоор үнэлэлт, дүгнэлт өгнө.

4.2. Ослын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, ангилах, авах арга хэмжээний цар хүрээг тодорхойлох зорилгоор ослын нөхцөл байдлыг 3 үе болгон хуваана:

4.2.1. Тодорхой бус үе /INCERFA/ буюу агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдын аюулгүй байдлын талаар эргэлзээтэй байдал үүссэн үе. Энэ үеийг дараах тохиолдлуудад зарлана:

- агаарын хөлөг илтгэх ёстой цагаас хэтэрсэн, түүнтэй холбоо тогтоох гэсэн оролдлого бүтэлгүй болсноос хойш 15 минутын турш уг агаарын хөлгөөс ямар нэг мэдээлэл аваагүй бол;

- агаарын хөлөг нисэн ирэх тооцоот цагаас хоцорсон, нислэгийн хөдөлгөөний албаны тооцоолсон цагаас 30 минут өнгөрөхөд буулт үйлдэх аэродромдоо ирээгүй бол.

4.2.2. Түгшүүрийн үе /ALERFA/ буюу агаарын хөлөг, түүний нисэх баг, зорчигчдод аюул учирч болзошгүй нөхцөл байдал бий болсон үе. Энэ үеийг дараах тохиолдлуудад зарлана:

- тодорхой бус үеийн дараа агаарын хөлөгтэй холбоо тогтоох, бусад эх сурвалжаас түүний талаар мэдээлэл авах гэсэн аливаа оролдлого үр дүнгүй болсон бол;

- агаарын хөлөг буулт үйлдэх зөвшөөрөл авсны дараа 5 минутын дотор буулт үйлдээгүй, түүнтэй холбоо барьж чадаагүй бол;

- агаарын хөлгийн үндсэн системүүд татгалзсан, гэхдээ энэ байдал нь уг агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх шалтгаан болохгүй гэсэн мэдээлэл авсан бол;

- агаарын хөлөг хөндлөнгийн гэмт халдлагад өртсөн нь тодорхой болсон, эсхүл тийм таамаглал бий болсон бол.

4.2.3. Аюулын үе /DETRESFA/ буюу агаарын хөлөг, түүний нисэх баг, зорчигчдод ноцтой аюул тулгарч, тусламж дэмжлэг зайлшгүй болсон үе. Энэ үеийг дараах тохиолдлуудад зарлана:

- түгшүүрийн үеийн дараа агаарын хөлөгтэй холбоо тогтоох, нөхцөл байдлыг тодруулахаар аливаа эх сурвалжаас мэдээлэл авах бүх оролдлого бүтэлгүйтсэн, агаарын хөлөг осолд орсон байж болох магадлал бий болсон;

- агаарын хөлгийн шатахууны нөөц бүрэн зарцуулагдсан, аюулгүй буулт үйлдэх аэродром хүрэхэд хүрэлцэхгүй гэсэн тооцоо гарсан;

- агаарын хөлгийн үндсэн системүүд татгалзсаны улмаас аргагүйдсэн буулт үйлдэх болсон тухай мэдээлэл хүлээн авсан;

- агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх болсон.

Тав. Ослын нөхцөл байдлын үе шатуудад авах арга хэмжээ

5.1. ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас өгсөн мэдээллийг үндэслэн Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч “тодорхой бус үе”-ийг зарлаж, дараах арга хэмжээг авна:

- хүлээж авсан мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгах;
- нислэгийн үе дэх онцгой тохиолдол, агаарын хөлгийн системийн татгалзал, ослын талаар холбогдох албан тушаалтнуудад мэдээлэл өгөх;
- төлөвлөгөөт бус нислэгийн үед тухайн агаарын хөлгийн нислэг үйлдсэн агаарын зам, нисэн гарсан болон буух тооцоот цагийг тодруулахад тус болохуйц мэдээлэл олж авах оролдлого хийх;
- хүлээн авсан шинэ мэдээлэлд үнэлэлт, дүгнэлт өгөх, агаарын хөлгийн байрлал, түүний туулсан замыг газрын зураг дээр тодорхойлох;
- бүх мэдээллийг нэгтгэн дүгнэсний эцэст агаарын хөлгийн байрлал, чиглэлийг газрын зураг дээр тэмдэглэх.

5.2. Холбооны хэрэгслээр эрэл, хайгуул хийх:

- тухайн агаарын хөлөгтэй холбоо тогтоох оролдлогыг боломжтой бүх үелзлэл дээр хийх;
 - тухайн агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох оролдлого хийх.
- Үүнд: буулт үйлдэх бололцоотой бүх аэродром болон бусад газраас /нисэн гарсан аэродромыг оролцуулан/ уг агаарын хөлгийн талаар лавлах. Бусад эх сурвалжтай холбоо тогтоох, тухайлбал уг агаарын хөлөгтэй нэг агаарын замд ниссэн мөн радио холбооны алслалтын хүрээнд байсан агаарын хөлгүүдтэй холбоо тогтоож асуух;
- эрэл, хайгуулыг хийсний эцэст эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэж үзвэл эрэн хайх, авран туслах бүлгүүд болон үйл ажиллагаанд оролцох байгууллага, албадад мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ аюул тулгарсан, аюулд нэрвэгдсэн агаарын хөлгийг дагалдуулах шаардлага гарвал өөр агаарын хөлөг илгээх саналыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчид тавьж болно.

5.3. Хэрэв агаарын хөлөг болон түүний нисэх баг, зорчигчдын аюулгүй байдлын талаар эргэлзээтэй нөхцөл байдал хэвээр байвал “тодорхой бус үе”-ийг дуусгаж, “түгшүүрийн үе” рүү шилжинэ.

Зургаа. “Түгшүүрийн үе”-д авч хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1. “Түгшүүрийн үе” эхэлснийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч болон ИНЕГ-ын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба зарлана.

6.2. “Түгшүүрийн үе” зарлагдсан тохиолдолд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч дараах арга хэмжээг авна:

6.2.1. Тухайн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авч эхэлсэн тухайгаа ЗХЖШ-ын даргад мэдэгдэх;

6.2.2. Бий болсон нөхцөл байдлын талаарх мэдээллийг ЭХАТ үйл ажиллагаанд оролцох байгууллага, албадад хүргэж, бэлэн байдалд оруулах;

6.2.3. Бий болсон нөхцөл байдалд нийцүүлэн нислэг–техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссыг томилж, ажиллуулах саналыг ЗХЖШ-ын дарга болон Батлан хамгаалахын сайдад тавих;

6.2.4. Хүлээн авсан мэдээллийг нягтлан шалгах;

6.2.5. Ослын нөхцөл байдалд орсон агаарын хөлгийн талаарх шинэ мэдээллийг урьд нь холбоогүй байсан газруудаас авах оролдлого хийх. Үүнд:

- агаарын хөлөгтэй холбоо тогтоосон байж болзошгүй улсын болон иргэний нисэхийн нисэх буудлууд, Зэвсэгт хүчний, ялангуяа байнгын жижүүрлэлтэд байгаа Зэвсэгт хүчний Агаарын цэргийн болон ХХЕГ-ын харъяа анги, салбарууд, бусад газраас мэдээлэл авах, эдгээр байгууллагуудыг бололцоотой бол 121.5 мГц, 5680 кГц үелзлэлд холбоо тогтоох хүсэлт тавих;

- ЭХАТ үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хамтарсан ажиллагааны гэрээ байгуулсан бусад байгууллага, албадаас мэдээлэл авах.

6.2.6. Нислэгийн төлөвлөгөө, цаг агаарын болон газар орны байдал, радио холбоо сааталд орох магадлал, агаарын хөлгийн байрлалын талаар холбогдох байгууллага, албадтай мэдээлэл солилцох;

6.2.7. Хүлээн авсан шинэ мэдээлэлд үнэлэлт дүгнэлт өгөх, агаарын хөлгийн байрлал, түүний туулсан замыг газрын зураг дээр тэмдэглэх.

Долоо. “Түгшүүрийн үе”-ийг дуусгаж, “аюулын үе”-д шилжих

7.1. Хэрэв агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох талаар авсан бүх арга хэмжээ үр дүнгүй болсон, шатахууны нөөц нь дууссан, тооцоот цаг өнгөрсөн тохиолдолд агаарын хөлөг болон түүний нисэх баг, зорчигчдод аюул тулгарсан бөгөөд тэдэнд яаралтай тусламж шаардагдаж байна гэж үзэн “аюулын үе”-д шилжинэ.

7.2. “Аюулын үе”-ийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, эсхүл ИНЕГ-ын нислэг хөдөлгөөний үйлчилгээний алба зарлан мэдэгдэнэ.

7.3. “Аюулын үе”-ийг зарласны дараа Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч дараах арга хэмжээг авна:

- байгаа бүх мэдээлэлдээ үндэслэн эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа явуулах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах;

- төлөвлөгөөний холбогдох хэсгийг дараах алба, байгууллагуудад илгээнэ:

- аюул тулгарсан байж болзошгүй агаарын хөлөгт дамжуулах болон нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанд;

- хэрэв агаарын хөлөг улсын хилийн бүсэд нислэг үйлдэж байсан бол ХХЕГ-т;

- агаарын хөлөгт аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн тухай мэдээ авмагц ОБЕГ-т;

- агаарын хөлгийн байрлалыг тодорхойлох, эрэн хайх үйл ажиллагаа явагдах бүсийн хэмжээг тодорхойлох;

- эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны “Аюулын үе”-ийн эхний шатанд уг үйл ажиллагаанд шууд оролцохгүй боловч шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлж чадах агаарын хөлөг, байгууллага, хувь хүмүүст дараах хүсэлтийг тавина:

- осолд нэрвэгдсэн байж болзошгүй агаарын хөлгийн дамжуулах дохиог хүлээн авах зорилгоор радио холбооны суваг сонгох, агаарын хөлгийн ослын мэдээг дамжуулагч, чиглүүлэгч тоноглолуудын дохиог сонсох;

- осолд орж болзошгүй агаарын хөлөгт бүх талын тусламж үзүүлэх.

Найм. Эрэн хайх авран туслах үйл ажиллагааг эхлэх

8.1. Монгол Улсын агаарын орон зайд нислэг үйлдэж байсан агаарын хөлөг ослын нөхцөл байдалд орсон нь тодорхой болсон тохиолдолд Батлан хамгаалахын сайдын шийдвэрийг үндэслэн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг ЗХЖШ-ын дарга эхлүүлж, хяналт тавина.

8.2. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч нь тухайн цагийн байдлаас шалтгаалан эрэн хайх, авран туслах хүч хэрэгслийг бэлэн байдлын тогтоосон зэргүүдийн аль нэгэнд шилжүүлнэ.

Ес. Эрэн хайх, авран туслах ажиллагааг явуулах

9.1. Эрэн хайх, авран туслах ажиллагааг ЗХЖШ-ын даргын баталсан удирдамжийн дагуу явуулна.

Арав. Агаарын хөлөг олдсоны дараа авах арга хэмжээ

10.1. Агаарын хөлгөөр эрэл хийсний үр дүнд осолдсон агаарын хөлгийг илрүүлсэн тохиолдолд агаарын эрэн хайх, авран туслах нислэг үйлдсэн агаарын хөлгийн баг осолдогсдод дараах аргуудын аль нэгийг хэрэглэн дохио өгнө:

- буултын гэрлээ асааж, ослын талбар дээгүүр нам өндөрт нисч, далавчаараа дохиж;

- дохиоллын чийдэн болон гэрлийн прожекторыг асааж унтраах;
- дохионы гар буугаар 5-10 секундын зайтайгаар буудах /ногоон өнгийн сум байвал илүү тохиромжтой/;

10.1.1. Шаардлагатай тохиолдолд холбооны хэрэгсэл, хоол хүнс болон эм тариа, амьдрал тэтгэх бусад эд зүйлсийг онгоцноос хаях, хэрэв шүхэрчин аврагчид ажиглагчаар явсан бол тэднийг буулгах;

10.1.2. Ослын талбар дээгүүр тойрог нислэг үйлдэн байрлалыг нь сайтар тогтоох, газрын зураг дээр тэмдэглэх;

10.1.3. Осолдсон агаарын хөлгийг илрүүлсэн тухай дараах мэдээллийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчид дамжуулах. Үүнд:

- илрүүлсэн цаг;
- осолдсон агаарын хөлгийн байрлал;
- ослын талбар дээрх нөхцөл байдал;
- осолдогсдын байдал;
- шаардлагатай авран хамгаалах тоноглол, бусад материал хэрэгсэл;
- осолд өртөгсдөөс өгч буй ил харааны дохио, радио холбооны хэрэгслээр дамжуулсан мэдээ;
- цаг агаарын байдал;
- агаарын хөлөг буулт үйлдэх боломжтой эсэх, ослын талбарын ойролцоо аврагчид болон эмнэлгийн ажилтнууд шүхрээр буух боломжтой газар байгаа эсэх;
- газрын эрэн хайх, авран туслах бүлэг ослын талбар руу шуурхай саадгүй хүрэлцэн очих хамгийн дөт зам, маршрут;
- ослын талбарт хамгийн ойр байгаа суурин газар;
- энэ мэдээллийг дамжуулахаас өмнө ямар нэг арга хэмжээ авсан эсэх, осолд өртөгсдөд ямар тусламж үзүүлсэн;
- өөрийн агаарын хөлөгт үлдсэн шатахууны хэмжээ болон аэродромдоо нисэн очих тооцоот цаг;
- авран туслах үйл ажиллагааны үед учирч болзошгүй аюул саад бэрхшээл.

10.1.4. Ослын талбарыг болон осолдсон агаарын хөлгийг баримжаалах онцгой, содон тэмдэгт болон объектын хамт багтаасан фото зураг /видео бичлэг/-ийг янз бүрийн өндрөөс авах;

10.1.5. Ослын талбарт хүрэх замыг газрын эрэн хайх, авран туслах бүлгүүд болон бусад агаарын хөлгүүдэд зааж өгөх.

10.2. Газрын эрэн хайх, авран туслах бүлэг осолдсон агаарын хөлгийг олсон тохиолдолд дараах арга хэмжээг авна:

- бий болсон нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчид шаардлагатай бүх мэдээллийг шуурхай дамжуулах;

- осолдогсдод эмнэлгийн анхны тусламж үзүүлж, тэднийг нүүлгэн шилжүүлэхэд бэлтгэх;

- шинжлэн шалгах бүрэлдэхүүнийг ослын талбар дээр хүрэлцэн иртэл ослын газарт үлдсэн аливаа ул мөр, агаарын хөлгийн эд ангиуд болон бусад зүйлийг байрнаас нь хөдөлгөхгүй байх /хэрэв энэ нь осолд нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэхэд саад болохгүй тохиолдолд/, ачаа тээш, баримт бичгийг хамгаалах.

Арван нэг. Эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг зогсоох

11.1. Осолд орсон агаарын хөлгийн байрлалыг тодорхойлж, аврах ажиллагаа явагдаж дууссаны дараа эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг зогсоох тухай саналаа ЗХЖШ-ын дарга Батлан хамгаалахын сайдад танилцуулж, гарсан шийдвэрийг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч агаарын хөлөг эзэмшигч байгууллага болон уг ажиллагаанд оролцож байгаа бүх байгууллага, эрэн хайх, авран туслах бүлгүүдэд нэн даруй мэдэгдэнэ.

11.2. Аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх бүх арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд “Улсын нисэхийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгээр шийдвэрлэнэ.

11.3. Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан эрлийг түр хугацаагаар зогсоож, шинэ, нэмэлт мэдээлэл олж авсны дараа эрэн хайх ажиллагааг үргэлжлүүлж болно.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны
.... дүгээр сарын-ны өдрийн дугаар
тушаалын долоодугаар хавсралт

УЛСЫН НИСЭХИЙН АГААРЫН ХӨЛГИЙН НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ОСОЛ
ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ДҮРЭМ
УНД-7

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмээр улсын нисэхийн нислэг–техникийн эвдрэл /гэмтэл/, осол, сүйрэл, нислэгийн сүйдлийн урьдчилсан нөхцөл үүссэн тухай мэдээлэл цуглуулах, ангилах, бүртгэх, шинжлэн шалгах, шалтгааныг тогтоох, дүгнэлт гаргах, аюулгүй ажиллагааны зөвлөмж бэлтгэх үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Энэ дүрмийг улсын агаарын хөлгийг эзэмшигч /цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллага болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх/ байгууллагууд дагаж мөрдөнө.

1.3. “Нисэхийн сүйдэл” гэж агаарын хөлгийн ашиглалтын явцад агаарын хөлөг эвдэрч гэмтсэн, түүнчлэн нисэх багийн гишүүд, зорчигчид бэртэл гэмтэл авсан, эсхүл аваагүй үйл явдлыг хэлнэ.

1.4. Нисэхийн сүйдлийг *нислэгийн, газрын* гэж ангилна.

1.4.1. “Нислэгийн сүйдэл” гэж нисэх баг нислэгийн үүрэг гүйцэтгэх явцад агаарын хөлөгт эвдрэл гэмтэл гарсан, хөлгийн бүхээгт байгаа хүмүүсийн амь насанд аюул учирсан, эсхүл амь нас хохирсон үйл явдлыг хэлнэ.

1.4.2. “Газрын сүйдэл” гэж нислэг үйлдэхээс өмнө буюу нислэг үйлдсэний дараа аэродром /талбай/ дээр болсон нисэхийн сүйдлийг хэлнэ.

1.5. Нислэгийн болон газрын сүйдлийг нисэх баг, зорчигч, агаарын хөлөгт учирсан хохирлоос хамаарч *эвдрэл (гэмтэл), осол, сүйрэл* гэж ангилна.

1.5.1. “Эвдрэл, гэмтэл” гэж нисэх багийн гишүүд, зорчигчдын амь нас эрсдээгүй, агаарын хөлөг эвдэрч гэмтсэн боловч түүнийг сэргээн засварлах боломжтой нисэхийн сүйдлийг хэлнэ.

1.5.2. “Осол” гэж нисэх багийн гишүүд болон зорчигчдын амь нас эрсдээгүй боловч агаарын хөлөг бүрэн эвдэрсэн, түүнийг техникийн хувьд сэргээн засварлах боломжгүй буюу эдийн засгийн хувьд үр ашиггүй нисэхийн сүйдлийг хэлнэ.

1.5.3. “Сүйрэл” гэж агаарын хөлгийн эвдрэл, гэмтлийн үед нисэх багийн гишүүд эсвэл зорчигчдоос амь нас эрсэдсэн, түүнчлэн хүндээр гэмтэгсэд сүйдэл болсноос хойш 10 хоногийн дотор нас барсан нислэгийн сүйдлийг хэлнэ.

1.6. “Алдаатай үйлдэл” гэж хүний санаатай бус үйлдлээр нислэгийг төвөгтэй болгосон, түүнийг тасалдуулсан, эсхүл хүсээгүй үр дүнд хүргэсэн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой алдааг хэлнэ.

1.7. “Ноцтой зөрчил” гэж ослын нөхцөл байдалд хүргэж болзошгүй зөрчлийг хэлнэ.

1.8. “Нисэхийн зөрчил” гэж осол, ноцтой зөрчлөөс бусад агаарын хөлгийн ашиглалттай холбогдсон агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй тохиолдлуудыг хэлнэ. Үүнд:

- Аюултай ойртолтоос зайлсхийх болон аюулын нөхцөл байдлаас гарах зорилгоор зайлшгүй хийгдсэн маневр үйл ажиллагаа;
- Нислэгийн зурвас хаалттай болон чөлөөлөгдөөгүй үед агаарын хөлгийг хөөргөх, буулгах;
- Гүйлт болон өндөр авалтын эхний шатанд агаарын хөлөг шаардлагатай үзүүлэлтүүдийг хангаж чадахгүй нь тодорхой болсон үед нислэгийг цаашид үргэлжлүүлэх;
- Зорчигчийн болон ачааны бүхээгт гал гарах, утаа орж ирэх, хөдөлгүүрт гал гарах;
- Нисэх багийг хүчилтөрөгчийн төхөөрөмжийг яаралтай ашиглахад хүргэсэн нөхцөл;
- Агаарын хөлгийн нислэгийн ашиглалтад нөлөөлж болох нэг болон түүнээс дээш систем ажилгүй болох;
- Нислэгийн үед нисэх багийн гишүүд хөдөлмөрийн чадвараа алдах;
- Нисэх багаас түлшний хэмжээний талаар аюулын дохио өгөх;
- Нислэгийн зурвасыг давах, дутах, хажуу тийш гарах;
- Системүүдийн татгалзал, цаг агаарын аюултай үзэгдлийн бүсэд орох, нислэгийн хязгаарлалтаас давах зэрэг агаарын хөлгийг удирдахад хүндрэл учруулсан нөхцөлүүд;
- Нислэгийг удирдах болон навигацийн хяналтын зайлшгүй шаардлагатай систем татгалзах.

1.10. “Аэродром дээрх зөрчил” гэж агаарын хөлгийн ашиглалтын явцад гарсан дараах зөрчлийг хэлнэ. Үүнд:

- аэродромын хаалт хашлага, барилга байгууламж, тэмдэг тэмдэглэгээ зэргийг мөргөж, шүргэснээс үүссэн;
- агаарын хөлгийн явгалах зам, талбайн гадаргуугийн гэмтлээс шалтгаалсан;
- аэродром дээрх тоног төхөөрөмжийн гэмтлээс шалтгаалсан;
- аэродром дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааврыг зөрчсөнөөс үүссэн зөрчлүүд.

1.11. “Нислэгийн хөдөлгөөний удирдлагаас шалтгаалсан зөрчил” гэж нислэгийн удирдагчийн алдаатай үйлдлээс агаарын хөлөг нислэг үйлдэх болон аэродром дээр явгалах үедээ өөр бусад агаарын хөлөг, газар дээрх барилга байгууламж, байгалийн саад зэрэгт аюултайгаар ойртсон болон тэдгээрээс зайлж гарах үед гарсан зөрчлийг хэлнэ.

1.12. “Агаар дахь гадны биетээс шалтгаалсан зөрчил” гэж агаарын хөлөг нислэгийн үед шувуу, эсхүл агаарт буй гадны биеттэй мөргөлдсөн болон хэт ойртсоны улмаас гарсан зөрчлийг хэлнэ.

1.13. “Аюултай ачаатай холбогдсон зөрчил” гэж агаарын хөлгөөр аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдсон зөрчлийг хэлнэ.

1.14. “Техникээс шалтгаалсан зөрчил” гэж агаарын хөлөг болон түүний эд анги, тоног төхөөрөмжийн гэмтэл, ажиллагааны доголдлоос шалтгаалсан зөрчлийг хэлнэ.

1.15. “Холбоо, навигацийн тоног төхөөрөмжөөс шалтгаалсан зөрчил” гэж газрын холбоо, навигаци, цахилгааны тоног төхөөрөмжид гарсан гэмтэл, дутагдлаас шалтгаалсан зөрчлийг хэлнэ.

1.16. “Мэдээлэлтэй холбогдсон зөрчил” гэж AIP /Aeronautical Information Publication/-ийн шугамаар түгээгдсэн алдаатай, бүрэн бус мэдээлэл болон алдаатай газрын зураг, баримт бичгийг ашигласнаас шалтгаалсан зөрчлийг хэлнэ.

1.17. “Нисэхийн аюулгүй байдалтай холбоотой зөрчил” гэж агаарын хөлгийн ажиллагаанд хөндлөнгийн хууль бус үйлдлийн улмаас гарсан зөрчлийг хэлнэ.

1.18. “Шалтгаан” гэж нислэг–техникийн эвдрэл /гэмтэл/, осол, сүйрэл, нисэхийн сүйдлийн урьдчилсан нөхцөлд хүргэсэн үйлдэл, хүчин зүйл болон нөхцөл байдлыг хэлнэ.

1.19. “Шинжлэн шалгах” гэж гарч болзошгүй нислэг-техникийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, түүнчлэн гарсан осол зөрчлийн шалтгааныг тогтоон аюулгүй ажиллагааны зөвлөмж бэлтгэх үйл ажиллагааг хэлнэ.

Хоёр. Шинжлэн шалгах ажиллагааны зорилго

2.1. Нисэхийн хэрэг явдлыг шинжлэн шалгах ажиллагааны зорилго нь эвдрэл гэмтэл, осол, зөрчил, сүйрлийн шалтгааныг үнэн зөв бодитоор тогтоох, тэдгээрийг цаашид давтагдахаас урьдчилан сэргийлэх талаар аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргахад оршино.

Гурав. Осол зөрчлийн тухай мэдэгдэх

3.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын агаарын хөлөгт тохиолдсон нислэг-техникийн осол, зөрчлийн тухай агаарын хөлгийг эзэмшигч болон бусад холбогдох байгууллагуудад мэдэгдэнэ.

3.2. Шаардлагатай тохиолдолд тухайн агаарын хөлгийг зохион бүтээгч, үйлдвэрлэгч байгууллага /улс/-д мэдэгдэнэ.

Б БҮЛЭГ. ШИНЖЛЭН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нэг. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс

1.1. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийн урьдчилсан нөхцөл үүссэн тухай асуудлыг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг улсын нисэхийн ерөнхий шинжээчийн ахалсан улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс гүйцэтгэх бөгөөд түүнийг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн томилно.

1.2. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажиллаж, улсын нисэхийн үйл ажиллагаанд хяналт тавина.

1.3. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс нь “Улсын нисэхийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг мөрдлөг болгон ажиллана.

1.4. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээч нь шаардлагатай гэж үзвэл “Улсын нисэхийн тухай” 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн дагуу комисс томилуулах тухай саналыг Батлан хамгаалахын сайдад тавьж шийдвэрлүүлнэ.

1.5. Нислэг-техникийн осол, зөрчлийн улмаас хүний амь нас хохирсон, хүнд гэмтэл авсан тохиолдолд шинжлэн шалгах үйл ажиллагаанд дадлага, туршлага бүхий шинжээч эмч нарыг оролцуулна.

1.6. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчил гарсан бүс /район/-ийн иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд “Иргэний нисэхийн тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, “Улсын нисэхийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заагдсан үүргийг биелүүлэхээс

гадна улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисст үйл ажиллагаагаа явуулахад нь шаардагдах дэмжлэг, туслалцааг цаг тухайд нь үзүүлэх үүрэгтэй.

Хоёр. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээчийн бүрэн эрх

2.1. Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилогдсон улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь “Улсын нисэхийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.2. Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь нислэг-техникийн осол, зөрчлийг шалган тогтоох үйл ажиллагааг явуулахдаа бусдаас хараат бус байна.

Гурав. Шинжлэн шалгах ажиллагаа

3.1. Шинжлэн шалгах комисс нь дараах дарааллаар ажиллана:

- Нислэг техникийн осол, зөрчлийн талаарх холбогдох мэдээллүүдийг цуглуулах, бүртгэх, ангилах;
- Шалтгааныг тогтоох, тайлан бичих;
- Дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- Акт үйлдэх;
- Аюулгүйн ажиллагааг хангахад чиглэсэн зөвлөмж гаргах.

Дөрөв. Осол, зөрчлийг шинжлэн шалгаж баримтжуулах

4.1. Шинжлэн шалгах бүрэлдэхүүн томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор урьдчилсан тайланг, 60 хоногийн дотор эцсийн тайланг гаргаж ерөнхий шинжээчид танилцуулна.

4.2. Ерөнхий шинжээч нь шинжлэн шалгах ажиллагаа эхэлснээс хойш 90 хоногийн дотор 4.1-д заасан тайлангуудад үндэслэн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааны талаарх ерөнхий дүгнэлтийг гаргаж, баталгаажуулна.

Тав. Осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дараах зөвлөмж

5.1. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтэс нь нислэгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авахуулах, зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж боловсруулж, улсын нисэхийн холбогдох байгууллагуудад яаралтай хүргүүлнэ.

5.2. Дүгнэлт, зөвлөмж хүлээн авсан байгууллага нислэгийн аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэгтэй.

В БҮЛЭГ. НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ

Нэг. Осол, зөрчлийн тухай мэдээлэх

1.1. Агаарын хөлөг осолдсон, сураггүй алга болсон, бүрэн эвдэрсэн болон нислэгийн зөрчил /нислэгийн үед агаарын хөлгүүд хоорондоо аюултай ойртсон, TCAS ажилласан г.м/ гарсан тохиолдолд ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба /НХҮА/, орон нутгийн нисэх буудлын ажилтнууд, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн төв командын байрын байлдааны удирдлагын оперативын жижүүр, нислэгийн хөдөлгөөний албаны нислэгийн удирдагч /нислэгийн хөдөлгөөний зохицуулагч/ нар энэ тухай ЗХЖШ-ын удирдлага, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч болон холбогдох бусад байгууллагуудад нэн даруй мэдээлнэ.

1.2. Мэдээлэлд дараах зүйлүүд тусгагдсан байна:

- алга болсон буюу осол гарсан он, сар, өдөр, цаг, минут;
- болсон явдал, байршил;
- осолд өртсөн агаарын хөлгийн улсын бүртгэлийн дугаар;
- тухайн агаарын хөлгийг эзэмшигч болон ашиглагчийн нэр;
- газар зүйн хувьд хялбар тодорхойлохуйц мэдээлэл бүхий агаарын хөлгийн байрлал буюу хамгийн сүүлд илтгэсэн байршил;
- агаарын хөлгийн даргын овог, нэр;
- нислэгийн үүрэг, зорилго;
- тухайн агаарын хөлгийн хамгийн сүүлд хөөрөлт үйлдсэн, холбоо барьсан нисэх буудал, газрын нэр;
- агаарын хөлгийн буухаар төлөвлөсөн нисэх буудал, газрын нэр;
- цаг агаарын нөхцөл байдал;
- агаарын хөлгийн бүхээгт явсан хүний тоо;
- ослын үед амь насаа алдсан, хүнд гэмтэл авсан нисэх багийн гишүүд болон зорчигчдын тоо;
- ослын улмаас гуравдагч этгээдэд учруулсан хохирлын талаарх мэдээлэл.

Хоёр. Ослын тухай нарийвчилсан мэдээлэл

2.1. Ослын үед аливаа этгээд амь насаа алдсан, хүнд гэмтэл авсан, агаарын хөлөг сураггүй болсон тохиолдолд агаарын хөлгийн дарга, агаарын хөлгийг эзэмшигч нь ослын тухай нарийвчилсан мэдээллийг осол гарснаас хойш 7

хоногийн дотор тусгай маягт /хавсралт 1, 2, 3, 4, 5/-ын дагуу бөглөж Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалд ирүүлнэ.

2.2. Осолд өртсөн нисэх багийн гишүүн бүр болсон явдлын талаарх тодорхойлолтыг тусгай маягтад заасны дагуу бөглөж ирүүлнэ.

2.3. Нисэх багийн гишүүн биеийн эрүүл мэндийн хувьд тодорхойлолт гаргаж өгөх боломжгүй тохиолдолд тодорхойлолтыг нөхөн гаргуулж авна.

2.4. Гарсан осол, зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээний тухай мэдээллийг нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах комисс хавсралт 6-д заасан маягтын дагуу бөглөж, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчид ирүүлнэ.

Гурав. Зайлшгүй мэдээлэх шаардлагатай осол, зөрчлүүдийн жагсаалт

3.1. Агаарын хөлгийн хийцэд учирсан гэмтэл:

- агаар болон газарт санамсаргүй шалтгаанаар, элэгдлийн улмаас үүссэн гэмтэл. Жишээ нь: зэврэлт, цууралт, деформац г.м;
- агаарын хөлгийн хийцийн хүчилсэн хэсэгт үүссэн, түүний аюулгүй байдалд нөлөөлөх болон нөлөөлж болзошгүй гэмтэл;
- тусгай үзлэг шалгалтаар илрүүлсэн аливаа гэмтэл;
- агаарын хөлгийн аль нэг хэсэг агаарт салж унах;

3.2. Зорчигч бэртэж, гэмтэх:

3.2.1. Агаарын хөлөг болон түүний эд ангийн ашиглалтын шууд нөлөөллөөр зорчигч бэртэж, гэмтэх.

3.3. Нисэх багийн гишүүд болон газрын үйлчилгээний бүрэлдэхүүн хөдөлмөрийн чадвараа алдсанаас ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй болох:

3.3.1. Нисэх багийн аль нэг гишүүн нислэгийн өмнө болон дараа ажиллах чадваргүй болох;

3.3.2. Газрын үйлчилгээний бүрэлдэхүүн /инженер техникийн бүрэлдэхүүн, нислэгийн удирдагч/ хөдөлмөрийн чадвараа алдсанаас агаарын хөлөг аюултай байдалд орох буюу орж болзошгүй байдал үүсэх;

3.4. Онцгой нөхцөл байдлыг арилгах зорилгоор авсан арга хэмжээнүүд:

- Газар болон агаарт аврах тоног төхөөрөмжүүдийг ашигласан буюу авсан аврах арга хэмжээ;
- Нисэх багийн гишүүдээс агаарын хөлгийг онцгой нөхцөл байдлаас гаргах зорилгоор ямар нэг стандартын бус ажиллагаа хийсэн;
- Онцгой нөхцөл байдал зарласан;

- Анхааруулсан болон аргагүйдсэн буулт хийсэн;
- Аврах тоног төхөөрөмжийн татгалзал /үүнд сургалт, туршилтын зорилгоор ашиглаж байгаа тоног төхөөрөмж ч орно/.

3.5. Агаарын хөлгийн систем, эд ангийн татгалзал.

3.5.1 Агаарын хөлгийн үндсэн болон туслах системийн эд ангиудын гэмтэл, дутагдал:

- хөдөлгүүр, түүний удирдлага;
- гидро системийн удирдлага;
- агаарын хөлгийн удирдлага;
- цахилгаан хангамжийн систем;
- агаар хангамжийн систем;
- мөсдөлт эсэргүүцэх систем;
- холбооны систем;
- навигацийн систем болон хэрэглэлүүд;
- дохиоллын төхөөрөмж болон системүүд;
- тормозны систем;
- дугуй, хөл ангийн удирдлагын систем.

3.5.2. Дараах нөхцөл байдлын улмаас агаарын хөлгийн үндсэн болон туслах системүүдийн эд ангиудад гэмтэл дутагдал:

- урьдчилан харах боломжгүй, болон аргагүйдсэн нөхцлийн улмаас;
- ашиглалтын стандартын журам, удирдах аргуудыг хангалтгүй биелүүлснээс;
- туслах систем болон орлох системүүдийн хангалтгүй ажиллагаанаас;
- дутагдал, татгалзлыг арилгах нисэх багийн хариу үйл ажиллагаа, шийдвэрийн үр дүнд үүссэн болон үүсэж болзошгүй аюултай нөхцөл;
- олон хөдөлгүүрт агаарын хөлгийн аль нэг хөдөлгүүрийн доголдол, татгалзал.

3.5.3. Дараах нөхцөл байдлын аль нэг нь үүсвэл:

- гал гарах, тэсрэх;
- агаарын хөлөг дотор хортой хий, утаа гарах;
- галын аюулд хүргэсэн болон хүргэж болзошгүй түлш, масло, гидро шингэнүүдийн гоожилт;

- түлшийг албадан юүлэх системийн гэмтлээс болж санамсаргүйгээр түлшийг их хэмжээгээр асгасан, галын аюул бий болсон, агаарын хөлгийн эд ангийг их хэмжээгээр бохирдуулсан;

- түлшийг албадан юүлэх систем бүрмөсөн ажилгүй болсон;
- түлш өгөх, хуваарилах ажиллагаанд нөлөөлсөн түлшний системийн гэмтлүүд;

- унтарсан хөдөлгүүрийг дахин асаах боломжгүй болсон;
- сэнсийг флюгердэх болон флюгерээс гаргах боломжгүй болсон;
- хөдөлгүүрийг унтраах, түүний эргэлтийг удирдах боломжгүй болсон;
- хөдөлгүүрүүд, стартер, генератор зэрэг өндөр эргэлттэй эд ангийн гэмтэл;

- хөдөлгүүр, сэнс, даах сэнс, туслах хөдөлгүүрийн эргэлт зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэх;

- далавчны закрылка, предкрылканы хамгаалах хавтангуудын хэвийн бус хазайлт;

- агаарын хөлгийн удирдлагын системийн ажиллагаа саатах, гэмтэх, ажлын шингэнүүд, удирдлагын хөдөлгөөн хязгаарлагдах;

- нисдэг тэрэгний сэнснүүдийн автомат тогтворжуулагчид гэмтэл гарах, ажилгүй болох;

- нислэгийн үед агаарын хөлгийн удирдлага хязгаарлагдах;

- нисэх багийн гишүүдийг төөрөгдөлд оруулж болзошгүй хэрэглэлийн системийн гэмтлүүд;

- дохиоллын системийн гэмтлүүд;

- заавал гүйцэтгэх шалгалтын явцад үндсэн систем, эд ангид илэрсэн ямар нэгэн дутагдал, доголдол, татгалзал;

- техникийн үйлчилгээ, их засварын үед илрүүлсэн, ашиглалтын ердийн нөхцөлд байж боломгүй элэгдэл, эвдрэл;

3.6. Нислэгийн үед агаарын хөлгийг удирдахтай холбоотой зөрчлүүд:

- агаарын хөлөг хөөргөлтийн хурд авсан үед зогсоох;
- агаарын хөлгийн удирдлагын системийн алдаанаас үүдэлтэй агаарын замын тогтоогдсон шугам ба өндрөөс хазайсан зориудын бус хазайлт;

- шийдвэр гаргах өндрөөс нам өндөрт хоёрдугаар тойрогт гарах;

- хөөргөх, буулгах зурвасын урд үзүүр болон газрыг санамсаргүйгээр шүргэсэн;

- хөөргөх буулгах зурвасын хажуу болон үзүүрээс давж гарсан;
- тормозны барилт муудсан;
- буултын оролтыг буруу аэродром буюу хөөргөх, буулгах зурваст

үйлдсэн;

• агаарын хөлгийн удирдлага ямар нэгэн шалтгаанаас алдагдах, жишээ нь агаарын урсгалын хуйлралт, сэгсрэлт гэх мэт;

- зориуд бусаар хурд алдах;
- зориуд бусаар автомат удирдлагаас гар удирдлагад гэнэт шилжих;
- эд анги, системийг шалгах, турших болон сургалтын зорилгоор

зориуд гэмтэл үүсгэснээс осол, зөрчил гарах.

3.7. Навигацийн төхөөрөмж ба холбооны хэрэгслийн ажиллагааны доголдол, татгалзал:

- навигацийн төхөөрөмжүүд гэмтэх ба бүрэн ажиллагаагүй болох;
- холбооны хэрэгслүүд гэмтэх ба бүрэн ажиллагаагүй болох.

3.8. Нислэгийн хөдөлгөөний газрын үйлчилгээний албадын алдаа зөрчлүүд:

• газрын албад алдаатай мэдээлэл тухайлбал, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, цаг уурын албанаас газрын зураг, схем, зааварт тусгасан алдаатай, зөрүүтэй мэдээлэл;

- нислэгийн тогтоогдсон өндрөөс нам өндөрт ниссэн тухай мэдээ;
- өндрийн хэрэглэлийг буруу ашигласан, эсвэл алдаатай ажилласан

тухай мэдээ;

• өндөр алдалтыг тогтоосон журмын дагуу гүйцэтгээгүй буюу буруу гүйцэтгэсэн;

• радиолокаторын болон байрлал тодорхойлох бусад төхөөрөмжүүдийн дэлгэц дээр агаарын хөлгийн байрлалыг буруу тодорхойлсон;

- чухал мэдээлэл, ойлголтыг буруу дамжуулсан;
- Аюултай ойртолт үүссэн.

3.9. Аэродромын төхөөрөмжүүдийн гэмтэл, дутагдлууд:

• аэродромын гэрэлтүүлэгт гэмтэл учрах ба бүрэн ажиллагаагүй болох;

- аэродромын талбайн хучилтын гэмтлүүд;
- аэродромын талбайд түлш их хэмжээгээр асгарсан;

• аэродромын талбай дээрх аюултай, саадтай хэсгийн тэмдэглэгээг алдаатай болон дутуу хийсэн, огт хийгээгүй;

- хөөргөх, буулгах зурвас, яваглах замыг гадны зүйлээр хаасан;
- аэродром дээр хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлгүүд өөр хоорондоо болон бусад тээврийн хэрэгсэл, газрын төхөөрөмжтэй мөргөлдсөн;
- аэродромд хөдөлгөөн үйлдэж байгаа агаарын хөлөг санамсаргүйгээр хиймэл хучилттай хэсгээс гарсан.

3.10. Нисэх баг нисэх мэдээлэл ба зааврыг буруу ойлгосон:

- хоёрдогч радиолокаторын кодыг буруу тавьсан;
- өгөгдсөн өндөр, чиглэлд нисээгүй;
- радиотелефоны чухал мэдээллийг буруу хүлээж авсан буюу ойлгосон.

3.11. Зорчигч, ачаа тээвэрлэх, ачаалалт хийх, түлш цэнэглэхтэй холбогдсон зөрчлүүд:

- агаарын хөлгийн хийцийн бат бөх байдал, нислэг-техникийн шинж чанар, төвлөрөлт, нислэгийн үргэлжлэлд ноцтойгоор нөлөөлөх хэмжээгээр /их, бага/ шатахуун цэнэглэсэн;
- бохир буюу өөр төрлийн түлш, масло, шингэнээр цэнэглэсэн;
- аюултай болон тусгай ачаа, байлдааны зэвсэглэл, техникийг тээвэрлэлтэд тавигдах шаардлагуудын дагуу ачаалаагүй;
- аюултай болон тусгай ачааны тэмдэглэгээ, шошгыг буруу хийсэн;
- зорчигч, ачааг агаарын хөлгийн төвлөрөлт, жинд нөлөөлөхөөр буруу байрлуулсан;
- ачаа, шуудан тээвэрлэснээр агаарын хөлгийн эд анги, бүтэц их хэмжээгээр бохирдсон.

3.12. Бусад зөрчлүүд:

- агаарт буй гадны биетээс шалтгаалсан зөрчлүүд;
- олон дахин давтагдаж байгаа гэмтэл, дутагдлууд;
- тэсрэлт, дэлбэрэлтээс үүссэн;
- агаарын хөлгийг булаах;
- агаарын хөлөг агаар, газарт аянга, цахилгаанд нэрвэгдсэнээс их бие, эд анги нь гэмтэх.

Г БҮЛЭГ. ОСОЛД ӨРТСӨН АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНИЙ ЭД АНГИ БОЛОН БИЧЛЭГИЙГ ХАМГААЛАЛТАД АВАХ

Нэг. Осолд өртсөн агаарын хөлөгт нэвтрэх

1.1 Хууль, дүрмийн дагуу эрх олгогдоогүй аливаа этгээд осолд өртсөн агаарын хөлөгт нэвтрэх буюу эд зүйлийг оролдох, байрнаас нь хөдөлгөхийг хориглоно.

1.2. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс нь шинжлэн шалгах ажиллагаа явуулах зорилгоор осолд өртсөн агаарын хөлгийг хамгаалалтад авах шийдвэр гаргах, түүнд нэвтрэх, шинжлэн шалгах үүднээс осолд өртсөн эд зүйлийг байрнаас нь хөдөлгөх эрхтэй.

1.3. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс нь дараах арга хэмжээг авч болно:

- шаардлагатай бол агаарын хөлөг, түүний эвдэрсэн бүрдэл хэсэг болон шуудан, ачаа тээшийг хөдөлгөх, цаашид гэмтэхээс хамгаалах;
- агаарын хөлгийн бүхээгийн яриа бичигч, нислэгийн өгөгдөхүүн бичигч, ослын байршил дохиологч зэргийг цахилгаан тэжээлээс салгаж ажиллагааг зогсоох;
- зайлшгүй шаардлагатай тохиолдолд, олон нийтэд болон нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагаанд саад учруулахаар байвал саадыг арилгах.

1.4. Агаарын хөлгийн эвдэрсэн бүрдэл хэсэг болон шуудан, ачаа тээшийг зөөж шилжүүлэхдээ:

- зөвхөн шинжлэн шалгах болон аюулгүй ажиллагааны шаардлагын үүднээс байрнаас нь хөдөлгөнө;
- тэдгээрийг агаарын хөлгийн аль хэсгээс авсанаа тэмдэглэн, ангилж байрлуулна;
- тэдгээрийн анхны байрлал болон эвдрэл гэмтэл авсан ул мөрийн гэрэл зургийг авч, гар зураглал болон тайлбар тэмдэглэлийг хавсаргана.

Хоёр. Баримт бичиг, бичлэгийг хамгаалалтад авах

2.1. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс нь осолд өртсөн агаарын хөлгийн нислэг, техникийн үйлчилгээний баримт бичиг, бүхээгийн яриа болон нислэгийн өгөгдөхүүн бичигчийн бичлэгийг шинжлэн шалгах ажиллагаа дуусч, ерөнхий шинжээчийн дүгнэлт гартал хамгаалалтад байлгана.

Гурав. Эвдэрч гэмтсэн эд ангийг хадгалах

3.1. Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь техникээс шалтгаалсан зөрчилд холбогдох эвдэрч гэмтсэн эд ангийг тусгайлан хадгална.

Хавсралт 1

1. Ерөнхий өгөгдлүүд

Асуулт	Мэдээллийн агуулга
Осол, зөрчил гарсан огноо	
Цаг	
Байршил	
Агаарын хөлгийн маяг, үйлдвэрлэгч	
Агаарын хөлгийн бүртгэл	
Эзэмшигчийн хаяг	
Гэмтэж бэртэгсдийн тоо	

Хавсралт 2

2. Үйл ажиллагааны тухай нарийвчилсан мэдээлэл

Асуулт	Мэдээллийн агуулга
Аяллын дугаар	
Өндөр	
Ашигласан хөөргөх, буулгах зурвас /ХБЗ/	
Нисэн гарсан цэг	
Нисэн очих цэг	
Илтгэл хийх хамгийн ойрын цэг (ИХХОЦ)	
Илтгэл хийх хамгийн ойрын цэг хүртэлх зай ба чиглэл	
Осол, зөрчил гарах үед ямар нислэг үйлдэж байсан болон нислэгийн ямар нөхцөл	
Нислэгийн төрөл	
Нислэгийн үе шат	
Нислэгт нөлөөлсөн хүчин зүйл	

Хавсралт 3

3. Болсон явдлын тодорхойлолт-хэсгийг бөглөх зөвлөмж

Асуулт	Мэдээллийн агуулга
Болсон явдлын тодорхойлолт	
Нисэх багийн гишүүний нэр	
Үнэмлэхний дугаар	
Сүүлийн 90 хоногт нисэх багийн гишүүний ниссэн цаг	
Тухайн ангиллын агаарын хөлгөөр ниссэн цаг.	
Нислэгийн нийт цаг	
Сүүлчийн шалгалт	

Шалгагчийн нэр	
Шалгасан огноо	
Шалгасан нисгэгчийн үнэмлэх	

Хавсралт 4

4. Осол зөрчлийн төрөл

Асуулт	Мэдээллийн агуулга
Осол /зөрчил/	
Агаарын зайн зөрчил	
Холбоо, навигацийн тоног төхөөрөмжийн гэмтэл зөрчил	
Аэродромын зөрчил	
Аюултай ачаатай холбоотой зөрчил	
Шувуунаас шалтгаалсан зөрчил	
Агаарын хөлгийн дутагдал /татгалзал/, техникийн зөрчил	

Хавсралт 5

5. Мэдээлэгчийн тухай

Асуулт	Мэдээллийн агуулга
Мэдээлэгчийн тухай	

Хавсралт 6

6. Гарсан осол, зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээний тухай мэдээлэл

Асуулт	Мэдээллийн агуулга
Осол, зөрчил гарсан огноо	
Цаг	
Байршил	
Агаарын хөлгийн маяг, үйлдвэрлэгч	
Агаарын хөлгийн бүртгэл	
Зөрчилд холбогдсон этгээдийн нэр	
Зөрчилд холбогдогч этгээдийн үнэмлэх	
Нислэгийн дүрэм, заавар зөрчсөн тухай	
Болсон явдлын тодорхойлолт	
Шалтгаан	
Осол зөрчлийн шалтгааныг бий болгосон этгээд, байгууллага	
Зөрчлийг арилгах талаар авсан арга хэмжээ	
Тооцсон, эсвэл бодит зардал	